



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/198

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 16/07 дугаар тогтоолоор батлагдсан "Хүн амын ахуйн үйлчилгээ- 2020" нийслэлийн дэд хөтөлбөрийн 3.3.12, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх" журмын 2 дугаар хэсгийн 2.4.1, 2018 оны А/577 дугаар захирамжаар батлагдсан "Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" нийслэлийн дэд хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 12, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчилах аяныг 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Дүүрэг тус бүрт дараах бүрэлдэхүүний төлөөллийг оролцуулан байгуулахыг дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

Дарга:	Дүүргийн Засаг даргын орлогч бөгөөд Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөлийн дарга
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс Дүүргийн Статистикийн хэлтэс Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс Дүүргийн Цагдаагийн хэлтэс Дүүргийн Онцгой байдлын хэлтэс Дүүргийн Татварын хэлтэс Хороодын Засаг дарга нар Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн ахуй үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

2. “Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчилах аян”-ы удирдамжийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.


3. Аяны арга хэмжээг хавсралтад заасан удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайланг фото зураг, судалгаагаар баталгаажуулан дүгнэж, илтгэх хуудсаар 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд ирүүлэхийг Ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчилах аяныг зохион байгуулахад шаардлагатай 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгийг 2 дугаар хавсралт ёсоор баталж, бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 03-ны өдрийн
А.198.9 утасны гэрээгээр авсралт



“НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН
ДУНД АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЛЭГ
ТЕХНОЛОГИЙГ СУРТАЛЧИЛАХ АЯН”-Ы
НЭГДСЭН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.8-д заасан “Хүн амын ахуйн үйлчилгээ-2020” нийслэлийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн ахуйн үйлчилгээний салбарт шинжлэх ухаан технологи, инновацыг нэвтрүүлэх, шинэ санаа, шилдэг технологийг дэмжих, сурталчилах, ахуйн үйлчилгээний ажилтнуудын мэргэжил, ур чадварын түвшинг дээшлүүлэх, хэрэглэгчдийн хэрэглээний зөв дадлыг төлөвшүүлэхэд оршино.

Хоёр. Аян зохион байгуулах бүрэлдэхүүн

“Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчилах аян”-ыг дүүрэг тус бүрт ажлын хэсэг байгуулж зохион байгуулна.

Гурав. Зохион байгуулах хугацаа

2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулна.

Дөрөв. Аяны хүрээнд хийгдэх арга хэмжээ, чиглэл

1. Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг томилон, аяны хугацаанд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлах;
2. Аяны хүрээнд дүүрэг бүр ахуйн үйлчилгээний салбарын суурь судалгааг үндэслэн иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй бүртгэлийг гаргаж, уялдаа холбоотой ажиллах;
3. Төрийн бус байгууллагууд, холбоо нөхөрлөл, сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
4. Шинэ санаа, шилдэг технологийг ахуйн үйлчилгээний салбарын бусад аж ахуйн нэгжүүдэд сурталчилан, үзүүлэх сургалт зохион байгуулах, үзэсгэлэн гаргаж тэргүүн туршлага, ажлын ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, үйлчилгээний чанар, соёл, хүртээмжийг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах;
5. Ажил мэргэжлийн аварга шалгаруулах уралдаан тэмцээн зохион байгуулах;

6. Дүүрэг бүр үзүүлэх сургалтыг батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, үр дүнг нэгтгэн танилцуулах;

7. Аяны хүрээнд хийгдэж буй ажлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр өргөн хүрээтэй сурталчлах.

Тав. Үр дүнг тайлагнах, урамшуулал олгох

1. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын талаарх дэлгэрэнгүй тайланг 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэст ирүүлнэ.

2. “Нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчилах аян”-ыг үр дүнтэй зохион байгуулж, идэвх, санаачлагатай оролцсон 3 дүүргийг шалгаруулан Нийслэлийн 380 жилийн ойг тохиолдуулан өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно. Үүнд:

1 дүгээр байр /1 дүүрэг/ - өргөмжлөл, 1.000.000 төгрөг,

2 дугаар байр /1 дүүрэг/ - өргөмжлөл, 600.000 төгрөг,

3 дугаар байр /1 дүүрэг/ - өргөмжлөл, 300.000 төгрөг.

3. Нийслэлийн ахуйн үйлчилгээний салбарт шинжлэх ухаан технологи, инновацыг нэвтрүүлэх, шинэ санаа, шилдэг технологийг сурталчилах, үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлж ажилласан 3 аж ахуйн нэгжийг шалгаруулна. Үүнд:

1 дүгээр байр /1 аж ахуйн нэгж/ - өргөмжлөл, 1.000.000 төгрөг,

2 дугаар байр /1 аж ахуйн нэгж/ - өргөмжлөл, 600.000 төгрөг,

3 дугаар байр /1 аж ахуйн нэгж/ - өргөмжлөл, 300.000 төгрөг.

Зургаа. Сонгон шалгаруулалт

1. Сонгон шалгаруулалтыг онооны системээр явуулах бөгөөд хамгийн их оноо авсан бүтээгдэхүүн, үйлчилгээг эрэмбэлнэ.

2. Ажлын хэсгийн гишүүд сонгон шалгаруулалтад санал өгөх эрхтэйгээр оролцох ба шударга тэгш өрсөлдөөний зарчмыг баримтлан, бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрийг дараах 5 шалгуур үзүүлэлтээр харгалзан үзэж 1-5 оноо өгч, дүгнэлт гаргах хэлбэрээр дүүрэг бүр тайлагнана. Үүнд:

2.1. Эдийн засгийн үр өгөөж;


2.2. Инноваци, шинэ санаа, шилдэг технологи нэвтрүүлсэн байх;

2.3. Хүний нөөц, ур чадвар;

2.4. Зах зээлийн эрэлт хэрэгцээ;

2.5. Үйлчилгээний соёл, иргэдийн сэтгэл ханамж.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 013 өдрийн
А/198 тушаалын 90/2019 хэвсрэлт



“НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН
ДУНД АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЛЭГ
ТЕХНОЛОГИЙГ СУРТАЛЧИЛАХ АЯН” ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Зардал	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо хэмжээ	Нийт үнэ /төг/
1	1 дүгээр байрны шагнал	1.000.000	2	2.000.000
2	2 дугаар байрны шагнал	600.000	2	1.200.000
3	3 дугаар байрны шагнал	300.000	2	600.000
4	Өргөмжлөл	33.333	6	200.000
	Нийт дүн			4.000.000